



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 73

Мандалговь

Автомашинд үнэлгээ тогтоож,
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт аймгийн иргэдийн төлөөлөгчийн хурлын тэргүүлэгчдийн 2017 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “ Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хэмнэлтийн тухай хуулийн дагуу татан төвлөрүүлсэн 4 байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 137,225,000 /нэг зуун гучин долоон сая хоёр зуун хорин таван мянга/ төгрөгийн балансын үнэтэй 4 ширхэг автомашины худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоон, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.


2. Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Адъяасүрэн)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэх;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхэд хяналт тавих;

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн
Үз. дугаар тогтоолын хавсралт

Худалдах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Хуулийн этгээдийн нэр	Тээврийн хэрэгслийн нэр	Улсын бүртгэлийн		Үйлд вэрл эсэн он	Ашигл алтад орсон он	Санхүүгийн тайланд тусгагдсан дүн	Хуримтлагдс ан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
			Сери	Дугаар						
1	Адаацаг сумын ЗДТГ	NISSAN, Murano	ДУЭ	2066	2004	2016	10,000,000	10,000,000	0.00	1,000,000
2	Баянжаргалан сумын ЗДТГ	Toyota, Land Cruiser	ДУА	9191	2006	2014	50,000,000	50,000,000	0.00	10,000,000
3	Цагаандэлгэр сумын ЗДТГ	Toyota, Land Cruiser	ДУА	3281	2004	2015	50,000,000	25,277,777.96	24,722,222.04	12,350,000
4	Дэлгэрцогт сум ИТХ	UAZ-315195-066	ДУА	3859	2014	2014	27,225,000	17,015,625	9,642,187,5	7,100,000
Нийт							137,225,000 /нэг зуун гучин долоон сая хоёр зуун хорин таван мянга/ төгрөг	102,293,402,9 6 /зуун хоёр сая хоёр зууг ерэн гурван мянга дөрвөн зуун хоёр төгрөг	34,364,409,54 /гучин дөрвөн сая гурван зуун жаран дөрвөн мянга дөрвөн зуун есөн төгрөг тавин дөрвөн мөнгө/ төгрөг	30,450,000 /гучин сая дөрвөн зуун тавин мянга/ төгрөг